

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭРГЭДЭХ ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ АЛБАНЫ
ГААЛИЙН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ БАТСҮХИЙН САЙХАНЗАЯАГИЙН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
			1	2	3	4	5
Зорилт 1. “Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх”							
1	Байгууллагын үйл ажиллагаа болон холбогдох хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарч буй мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, удирдлагыг мэдээллээр хангаж ажилласан байдал	Олон нийтэд түгээсэн мэдээллийн тоо, хувиар	Гаалийн байгууллагын үйл ажиллагаа, цаг үеийн холбогдолтой 223 мэдээ, мэдээллийг түгээсэн	1.Байгууллагын үйл ажиллагаа болон холбогдох хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулж, нийт түгээсэн мэдээ мэдээллийн тоо суурь төвшнөөс өссөн байна. 2.Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарч буй мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийнэ. Удирдлагыг тухай бүрд нь мэдээллээр хангаж ажилласан байна.	Биелэлт: 1.Байгууллагын үйл ажиллагаа болон гаалийн холбогдолтой хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах, ажлыг зохион байгуулж, тайлант хугацаанд “Монголын гааль” пэйж хуудас болон төрийн мэдээллийн нэгдсэн сайт www.gov.mn сайтад 231 мэдээ, постер, видео нийтлэгдсэн. Үүнээс 45 видео, 93 постер, 50 фото зурган мэдээлэл, 33 рийлс бэлдсэн бол “Гаалийн албан хаагчдын мэдээлэл солилцох” дотоод группд 4 видео, 6 мэдээ зэрэг нийт 231 гаруй мэдээ мэдээлэл пост хийж түгээсэн байна. “МОНГОЛЫН ГААЛЬ” твиттер хуудаст 33 рийлс, 93 постер, 50 фото зурган мэдээ зэрэг нийт 176 мэдээ мэдээллийг цаг алдалгүй тухай бүр нийтэд түгээж пост хийж ажилласан. 2. Гаалийн байгууллагын талаар цахим орчин, хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээгдэж буй мэдээлэлд дүн шинжилгээ хийх зорилгоор Энх-Арслан ХХК-тай хамтран ажиллаж “ГЕГ” болон салбарын бусад	2025.12.01 - 2025.06.10	100

					түлхүүр үгтэй холбоотой мэдээллийг ажлын өдрүүдэд, өдөр бүр 4 удаагийн давтамжтай шүүлт хийн тухай бүр "Гаалийн хэвлэлийн тойм" вайбер группд тавигдаж гаалийн байгууллагын удирдлагуудад шууд танилцуулж байна. 2025 оны эхний хагас жилийн байдлаар “Гаалийн хэвлэлийн тойм” группт давхардсан тоогоор 1291, давхардаагүй тоогоор 829 мэдээлэл илэрсэн байна. Эдгээр 829 мэдээллийн 71 нь эерэг, 221 нь сөрөг, 537 нь нейтрал утгатай байна. Мониторингоор илэрсэн 829 мэдээллийн 143 нь гаалийн байгууллагыг сурталчилсан буюу ОНХА-аас бэлтгэж түгээсэн гаалийн эх сурвалжтай мэдээлэл байснаас 56 нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагджээ. Эдгээр 56 мэдээний 12 нь телевиз, 37 нь сайт, 7 нь сонинд нийтлэгдсэн байна. 3.Хэвлэлийн рүүпүүдэд мэдээ мэдээллийг түгээж ажиллаж байна. Тухайлбал, Фейсбүүкээр дамжуулан 244 гишүүнтэй “Хэвлэлийнхэн”, 153 гишүүнтэй “Сэтгүүлч”, 247 гишүүнтэй “Хэвлэлийн төлөөлөгч”, 95 гишүүнтэй “Гаалийн мэдээ, мэдээлэл”, 249 гишүүнтэй “Хэвлэлийн бага хурал”, вайберын 44 гишүүнтэй “Гаалийн хэвлэлийн тойм”, 248 гишүүнтэй “Хэвлэлийнхэн”гэх мэт хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, сэтгүүлчдийн группт мэдээ, мэдээллийг ашиглаж болох байдлаар түгээн ажилласан 4.Удирдлагыг өдөр бүр 4 цаг тутам мэдээллээр хангаж ажилласан, удирдлагаас хариу өгөх шаардлагатай гэж чиглэл өгсөн 20 мэдээллийг боловсруулж хариу тайлбар өгөх ажлыг зохион байгуулсан. Хүрсэн түвшин: 1. “Монголын гааль” пэйж хуудас болон төрийн мэдээллийн нэгдсэн сайт www.gov.mn сайтад 214	
--	--	--	--	--	--	--

					мэдээ, постер, видео нийтлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 4 хувь өссөн үзүүлэлттэй байна. “МОНГОЛЫН ГААЛЬ” фэйсбүүк хаягт байршуулсан нийт мэдээллийн тоо өмнөх оны мөн үеэс 8 постоор ахиулсан буюу 4 хувиар нэмэгдсэн байна. Дагагчийн тоо өмнөх оны мөн үеэс 8 мянгаар нэмэгдэж 33 хувь өссөн байна. 2. 2024 оны хагас жилээр 1514, мэдээлэл илэрснээс 204 мэдээ буюу 13 хувь нь ОНХА-аас бэлтгэсэн гаалийн эх сурвалжтай байсан бол 2025 оны хагас жилд 829 мэдээлэл илэрснээс 143 нь буюу 17 хувь нь гаалийн эх сурвалжтай мэдээлэл байна. Энэ нь мониторингоор илрүүлсэн гаалийн үйл ажиллагаатай холбоотой түлхүүр үгээр илэрсэн нийт мэдээллийн тоо цөөрсөн ч ОНХА-ны эх сурвалжтай түгээсэн мэдээ мэдээллийн хувь 4 хувиар өссөн үзүүлэлттэй байна 3. Мэдээ бүрийг хэвлэлийн рүүппүүдэд түгээснээр ГБ-ын цахим мэдээллийн хэрэгслүүдийн хандалт нэмэгдсэн. Монголын гааль пэж хуудасны дагагч өнгөрсөн оны мөн үеэс 33 хувь, сайтын хандалт төрийн нэгдсэн цахим хуудасруу шилжсэн тул хэмжих боломжгүй байна. 4. Удирдлагыг тухай бүрд нь мэдээллээр хангасан байдал 100 хувь. Удирдлагаас хариу өгөх шаардлагатай гэж чиглэл өгсөн 20 сөрөг мэдээлэлд хариу өгөх ажлыг 100 хувь зохион байгуулж ярилцлага, мэдээ, албан хаягаас сэтгэгдэл бичих болон зарим тохиолдолд утсаар холбогдож хариу арга хэмжээ авч ажилласан.		
2	Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран мэдээлэл солилцох,	Олон нийтэд түгээсэн мэдээллийн тоо, хувиар	1.Хэвлэл мэдээллийн байгууллагаас ирсэн 40 гаруй мэдээлэл авах	1.Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай нээлттэй хамтран ажиллаж, байгууллагын	Биелэлт: 1.ОНХА телевизийн 20 гаруй байгууллага, 30 гаруй сайт, өдөр тутмын 3 сонины сэтгүүлчидтэй байнгын хамтын ажиллагаатай ажилладаг бөгөөд мэдээлэл авах хүсэлтийг нээлттэй хүлээн авч, ажиллаж байна	2025.01.01 - 2025.06.05	100

	байгууллагыг төлөөлөн хамтран ажиллах, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ярилцлага, мэдээлэл өгөх албан хаагчид мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгсөн байдал		хүсэлтийг шийдвэрлэсэн. 2.Чиг үүрэг хариуцсан нэгжтэй хамтран олон нийтэд түгээх шаардлагатай мэдээ, мэдээллийг боловсруулан ажилласан. 3.Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ярилцлага, мэдээлэл өгөх албан хаагчид мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байна.	нээлттэй ил тод байдлыг хангасан байна. 2. Чиг үүрэг хариуцсан ЗББНДБ, харьяа газар, хороодтой хамтран олон нийтэд түгээх шаардлагатай мэдээ, мэдээллийн төлөвлөөг авч нэгтгэн, шаардлагатай мэдээ, мэдээллийг тухай бүр боловсруулан ажиллана. 3.Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ярилцлага, бичлэгт оролцож буй албан хаагчдад зөвлөгөө өгч ажилласан байна.	2025 оны хагас жилд хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдээс ирсэн 36 хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэжээ. 2025 оны хагас жилийн байдлаар Гадаад худалдааны статистик мэдээллийг Bloomberg TV -тэй тогтмол хамтран ажиллаж түгээв. Мөн MNB TV, Eagle TV , NTV, TV-9, TV-5 зэрэг телевизүүдээр, ikon.mn, isee.mn, medee.mn, mnb.mn, Mnews.mn, montsame.mn, murch.mn, arslan.mn, ubn.mn, unuudur.mn, mass.mn зэрэг мэдээний сайтууд албанаас гаргасан мэдээг түгээн ажиллаж байна. Мөн ОНХА-аас Фейсбүүкээр дамжуулан 244 гишүүнтэй “Хэвлэлийнхэн”, 153 гишүүнтэй “Сэтгүүлч”, 247 гишүүнтэй “Хэвлэлийн төлөөлөгч”, 95 гишүүнтэй “Гаалийн мэдээ, мэдээлэл”, 249 гишүүнтэй “Хэвлэлийн бага хурал”, вайберын 44 гишүүнтэй “Гаалийн хэвлэлийн тойм”, 248 гишүүнтэй “Хэвлэлийнхэн”гэх мэт хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, сэтгүүлчдийн группт мэдээ, мэдээллийг ашиглаж болох байдлаар түгээн ажилласан 2.2025 оноос шинээр “Асуувал хариулъя” контентыг гаргаж эхэлсэн. Найруулагчийн зохиолыг гаргаж, мэдээлэл өгөх хэрэгцээ шаардлага, сэдвийг тодорхойлох саналыг ЗББНДБ-уудаас авч, 27 санал ирснээс 11 дугаарыг бэлтгэж олон нийтэд түгээсэн. 3.УХШИГГ, ЧХОУНБГГ, УБГГ -уудад Соёлын өвийн үндэсний төв, ЗТГ-тай хамтран 260; ЗҮГГ, СЭГГ томилолтоор ажиллаж 137 албан хаагч, нийт 397 хүнийг хамруулсан сургалтыг амжилттай зохион байгуулсан байна. 4.“Гааль” подкастын тайз, найруулагчийн болон нэвтрүүлгийн зохиолыг гаргаж УБГГ, СТ-тэй хамтран 2 дугаарыг бэлтгэн түгээсэн байна. 5.2025 онд өмнө мэдээлэл ярилцлага өгч байгаагүй 20 албан хаагчаас видео мэдээлэл авч ажилласан		
--	---	--	--	---	---	--	--

					байна. Эдгээр албан хаагчдын мэдээллийг зураг авалтаас 1-7 хоногийн өмнө бичгээр авч зөвлөмж өгсөн. Мөн нэг албан хаагчаас яриа авах хугацаа дунджаар 2-3 цаг, бичлэг 30-60 минут, эвлүүлэг хийх хугацаа 4 цаг байна. Хүрсэн түвшин: 1. Хэвлэл мэдээллийн байгууллагатай мэдээлэл солилцох, байгууллагыг төлөөлөн ажиллахтай холбоотой харилцаанд гомдол гаргасан хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлч байхгүй. Хүсэлтийг 100 хувь шийдвэрлэж ажилласан. 2. “Асуувал хариулъя” контентыг Монголын гааль пэйж хуудсаар сард дунджаар 8 мянга гаруй үзэлт хандалтыг авсан байна. 3. Соёлын өвийн үндэсний төвтэй хамтарсан сургалтад дөрвөн гаалийн газар, хорооны алба хаагчид 80 гаруй хувийн оролцоотой хамрагдсан байна. 4. УБГГ, СТ-тэй хамтран бэлтгэсэн Гааль подкастын бичлэгийн хандалт 1-2 мянга, рийлсийн хандалт нь 70 мянгад хүрсэн байна 5. Тайлант хугацаанд Гаалийн байгууллагын вэб сайт, цахим хуудсанд мэдээлэл бэлтгэн өгсөн 20 албан хаагчаас ОНХА-аас өгсөн мэргэжил арга зүйн төлөвлөгөөг үнэлүүлэхэд ○ текстээр зөвлөгөө авсан 100 хувь ○ ярих ур чадварын талаар өгсөн зөвлөгөөг 13 нь хангалттай сайн, 5 сайн 2 дунд гэж бөглөсөн ○ хувцаслалт болон камертай харилцах зөвлөмжийг хангалттай гэж 61.1 хувь, сайн гэж 22.2 хувь 11.1 дундаж , муу 5.6 хувьтай үнэлсэн байна.	
--	--	--	--	--	---	--

3	Байгууллагын цахим хуудсыг шинэчлэн хөгжүүлэх	Олон нийтэд түгээсэн мэдээллийн тоо, хувиар	1.Байгууллагын цахим хуудсыг тогтмол хөтөлж хөгжүүлж, Цахим хөгжлийн яаманд 2022 оны ажлаа “А” үнэлгээтэй амжилттай дүгнүүлсэн. 2.Байгууллагад хамаарах, хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад 26 мэдээллийг үнэн зөв, ил тод байршуулсан. 3.Харьяа гаалийн газар, хороодын цахим хуудасны шинэчлэл 50 хувьтай хийгдсэн.	1.Байгууллагын цахим хуудсыг тогтмол хөтөлж хөгжүүлж, Цахим хөгжлийн яаманд 2023 оны ажлаа 95 хувиас дээш “А” үнэлгээтэй дүгнүүлнэ. 2.Байгууллагад хамаарах, хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг ЗББНДБ-уудаас авч тухай бүр нь үнэн зөв, ил тод байршуулна. 3.Харьяа гаалийн газар, хороодын цахим хуудасны шинэчлэл 60 хувиас дээш хийгдсэн байна.	Биелэлт: 1. Засгийн газрын 2024 оны 208 дугаар тогтоолоор төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байх, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг нэмэгдүүлэх зорилгоор “Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас gov.mn” сайтыг ашиглалтад оруулсантай холбоотойгоор Гаалийн байгууллагын цахим хуудсанд Мэдээллийн технологийн газартай хамтран 10 цэс шинээр үүсгүүлж 10 төрлийн нийт 127 мэдээ, мэдээллийг шинэчлэн байршуулж ажиллав. Мөн бусад нээлттэй мэдээллийг ЗББНДБ-уудаас тухай бүр нь авч үнэн зөв, ил тод байршуулж байна. Мөн МТГ-тай хамтран 19 газар, хороодын цахим хуудсыг толгой байгууллагад нэгтгэн газар хороо тус бүрд шинэ цахим хуудаст нэвтрэх нэр, нууц үгийг үүсгэн өгч, нэг форматын дагуу мэдээлэл бэлтгэн, байршуулж ажиллах талаар заавар, чиглэл өгөв. 2. Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор батлагдсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ын дагуу 48 мэдээллийг gov.mn сайт болон shilen.gov.mn сайтуудад байршуулсан. Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газраас Гаалийн байгууллагыг 2025 оны 1 дүгээр улиралд 94.7%-аар дүгнэсэн. Мөн Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолоор батлагдсан “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам” болон 2022 оны 352 дугаар тогтоолоор батлагдсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-д заасны дагуу shilen.gov.mn системд байгууллагын нээлттэй мэдээлэл байршуулах, ил тод байдлын шалгуур	
---	---	---	--	---	--	--

					үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийлгэх талаарх <u>цахим сургалтыг</u> Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газартай хамтран 05 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулсан. Сургалтад 19 харьяа газар, хорооноос 49 албан хаагч хамрагдаж, shilen.gov.mn системийн ерөнхий ойлголт, хэрэглээ, нээлттэй мэдээлэл байршуулах заавар зөвлөмж, болон хууль тогтоомжийн хэрэгжилт, үнэлгээ хийх журмын талаар мэдээлэл авсан. Харьяа гаалийн газар, хороодод шалгуур үзүүлэлтийн дагуу мэдээллийг gov.mn болон shilen.gov.mn сайтуудад байршуулах ажлыг сүүлийн хагас жилд багтаан хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. 3. Журамд заасны дагуу нийслэлд байрлах харьяа газар хороо болох УХШИГГ, УБГГ болон ЧХОУНБГГ-ыг бүртгэж, холбогдох алба хаагчдад shilen.gov.mn хуудсанд нэвтрэх нэр, нууц үгийг үүсгэж өгсөн. 4. Засгийн газрын 96-р тогтоолын дагуу “Нээлттэй өгөгдлийн жагсаалт”-ыг шинэчлэн баталсан. Гаалийн байгууллага үүнд хамаарах 9 нээлттэй мэдээллийг opendata.gov.mn сайтад заасан хугацаа бүрд шинэчлэн оруулдгаас ОНХА 6 мэдээллийг хариуцаж ажилладаг. Үүнтэй холбоотой бусад мэдээллийг ЗББНДБ-уудаас авч тухай бүр нь үнэн зөв, ил тод байршуулж байна. Хүрсэн түвшин: 1. Ажлын гүйцэтгэлийг хувиар үнэлбэл gov.mn сайтын цэс үүсгэх 100 хувь, мэдээлэл байршуулах 100 хувь, 19 газар, хороодын цахим хуудсыг толгой байгууллагад нэгтгэн газар хороо тус бүрд шинэ цахим хуудаст нэвтрэх нэр, нууц үгийг үүсгэн өгөх 90 хувь, мэдээлэл оруулах 70 хувьтай байна.	
--	--	--	--	--	--	--

					2. shilen.gov.mn гаалийн байгууллагыг 2025 оны 1 дүгээр улиралд 94.7%-аар дүгнэсэн. 2-р улирлыг 06 дугаар сарын 30-нд дүгнүүлнэ. 3. УХШИГГ, УБГГ болон ЧХОУНБГГ-ын бүртгэл 100 хувь, shilen.gov.mn хуудсанд нэвтрэх нэр, нууц үгийг олгох 100 хувь байна. 4. opendata.gov.mn сайтад гаалийн байгууллагаас байршуулах нийт 9 мэдээллээс 6 нь байршсан. Үлдсэн 3 мэдээлэл нь СДШХ хариуцдаг.		
4	Гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой видео танилцуулга, хэвлэлийн эх бэлтгэсэн байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 32 бичлэг, видео, 58 постер, 65 зураг, бэлтгэсэн	Гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой бичлэг, видео, постер, зураг бэлтгэн, удирдлагуудад танилцуулан нийтэд хүргэсэн байна.	Биелэлт: 1. “МОНГОЛЫН ГААЛЬ” фэйсбүүк хаягт 45 видео, 93 постер, 50 фото зурган мэдээлэл, 33 рийлс хэлбэрээр, мөн “Гаалийн албан хаагчдын мэдээлэл солилцох” дотоод группд 4 видео, 6 мэдээ зэрэг нийт 231 гаруй мэдээ мэдээлэл пост хийж түгээсэн байна. 2. “МОНГОЛЫН ГААЛЬ” твиттер хуудаст 33 рийлс, 93 постер, 50 фото зурган мэдээ зэрэг нийт 176 мэдээ мэдээллийг цаг алдалгүй тухай бүр нийтэд түгээж пост хийж ажилласан. 3. Хэвлэлийн группүүдэд мэдээ мэдээллийг түгээж ажиллаж байна. Тухайлбал, Фейсбүүкээр дамжуулан 244 гишүүнтэй “Хэвлэлийнхэн”, 153 гишүүнтэй “Сэтгүүлч”, 247 гишүүнтэй “Хэвлэлийн төлөөлөгч”, 95 гишүүнтэй “Гаалийн мэдээ, мэдээлэл”, 249 гишүүнтэй “Хэвлэлийн бага хурал”, вайберын 44 гишүүнтэй “Гаалийн хэвлэлийн тойм”, 248 гишүүнтэй “Хэвлэлийнхэн” гэх мэт хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, сэтгүүлчдийн группт мэдээ, мэдээллийг ашиглаж болох байдлаар түгээн ажилласан Хүрсэн түвшин: 1. “МОНГОЛЫН ГААЛЬ” фэйсбүүк хаягт байршуулсан нийт мэдээллийн тоо өмнөх оны мөн үеэс 8 постоор ахиулсан буюу 4 хувиар нэмэгдсэн байна.	2025.01.01 - 2025.06.05	98

					2. Тасралтгүй давтамжтайгаар пост оруулж явснаар "Монголын гааль" хуудас 2024 оны эхний хагас жилд 24 мянган дагагчтай байсан бол 2025 оны хагас жилд 32 мянган дагагчтай болж өмнөх оноос 33% өссөн байна. 3. Мэдээ бүрийг хэвлэлийн группүүдэд түгээснээр ГБ-ын цахим мэдээллийн хэрэгслүүдийн хандалт нэмэгдсэн төдийгүй олон нийтийг гаалийн тухай мэдээллээр ханган ажилласан.		
5	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Олон нийттэй харилцах албаны үйл ажиллагаанд хамааралтай бодлогын баримт бичгүүд байгаагүй болно.	Бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнана.	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилттэй холбоотой үүрэг даалгавар ОНХА-нд өгөөгүй болно.	2024.12.01 - 2025.06.10	98
6	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Чиг үүрэгт хамаарах хууль тогтоомж, эрх зүйн актыг хэрэгжилтийг хангаж ажиллан, хэрэгжилтийг хугацаанд нь хүргүүлэн ажилласан.	Олон нийттэй харилцах албаны холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилтийг хангаж ажилласан талаар тайлагнана.	<u>Биелэлт:</u> -Гаалийн хууль тогтоомж, эрх зүйн акт болон байгууллагын үйл ажиллагааг гаалийн харилцаанд оролцогчид, олон нийтэд хүргэх зорилгоор 143 мэдээ, мэдээллийг gov.mn цахим сайт, Монголын гааль пэйж хуудсанд 231 мэдээ байршуулсан - gov.mn цахим хуудасны Эрх зүй буланд 76 олон улсын гэрээ, гаалийн багц хуулиуд байршуулсан байсныг шинэчилсэн байна. <u>Хүрсэн түвшин:</u> -Олон нийттэй харилцах албаны холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. -Монгол Улсын ЗГ-ын 2022 оны 201 болон 352 дугаар тогтоолоор батлагдсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”, Засгийн газрын 96-р тогтоолын дагуу “Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэхэд тавигдах шаардлага,	2025.01.01 - 2025.06.05	98

					ашиглах нөхцөл журам”, Засгийн газрын 2024 оны 208 дугаар тогтоолоор төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байх, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг нэмэгдүүлэх зорилгоор “Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас gov.mn” сайтыг ашиглалтад оруулсантай холбоотойгоор дээрх хууль тогтоомжуудын хэрэгжилтийг тус тус ханган ажиллаж байна. Эдгээр журмын хэрэгжилтийг хангаж ажиллах хүрээнд цахим хуудсыг тогтмол хөгжүүлж, өөрийн байгууллагад хамаарах хуулиар хаалттай, хязгаарлалтай гэж тогтоосноос бусад мэдээллийг нээлттэй ил тод байлгаж, 2025 оны 1-р улиралд 94.7 хувь гэж үнэлүүлсэн. -ОНХА-ны журмын төслийг батлуулахаар Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанд хэлэлцүүлэх материалыг хүргүүлээд байна.		
7	Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Шинээр 2024 онд нэмэгдсэн шалгуур үзүүлэлт тул 2023 онд төлөвлөгөөгүй.	Нэгжийн эрсдэлийг таньж тогтоож сан үүсгэнэ.	Биелэлт: 1. "ОНХА-ны эрсдэлийн сан"-аас 2025 онд дараах эрсдэлийг бууруулж, санд бүртгэсэн. Мэдээлэл түгээхэд шаардлагатай интернэт хурд, тоног төхөөрөмжийн асуудлыг шийдүүлж, хүний нөөцийн дутагдлыг нөхөж ажилласан. 2. Нэгжийн эрсдэлийн судалгааны санд албан хаагчдын албан өрөөний ажиллах нөхцөл хүйтэн, албан хаагчдын хэрэглэдэг техник хэрэгсэл тоног төхөөрөмжийн ашиглалт зарим талаар шаардлага хангахгүй байгаа тухай санал гарсан. Хүрсэн түвшин: 1. Нэгжийн эрсдэлийг таньж тогтоож сан үүсгэв. Нэгжийн эрсдэлийг 10.2 хувь бууруулж, нэгжийн бүтэц орон тоо бүрэн нөхөгдсөн. 2. Нэгжийн эрсдэлийн судалгааны санд бүртгэгдсэн саналыг “ГЕГ-ын албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2025 оны үйл ажиллагааны	2025.01.01 - 2025.06.05	98

					төлөвлөгөө"-нд тусгуулж ГЕГ-ын даргаар батлуулсан.		
8	Үүрэг даалгаврын биелэлт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Нийт 10 үүрэг даалгавар өгөгдсөн бөгөөд үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь 100 хувь оруулж ажилласан.	Өгөгдсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь бүрэн биелүүлж ажилласан талаар тайлагнана.	Биелэлт: ЗДАСП-т 4 үүрэг даалгавар, 11 зөвлөмж өгснийг биелэлтийг хугацаанд нь оруулсан. Edoc.ecustoms.mn программаар 135 албан бичиг, дотоод зурвас ирснийг хугацаанд нь шийдвэрлэж, 156 дотоод зурвас илгээсэн байна. Албаны долоо хоног бүрийн 5 өдөр тайланг гарган сөр программд тайлангаа оруулж, албаны даргад танилцуулж байна. Хүрсэн түвшин: Үүрэг даалгаврын биелэлтийг 100 хувь оруулж ажилласан.	2025.01.01 - 2025.06.05	98
9	Ажлын цаг ашиглалт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	2024 оны ажлын цаг ашиглалт 66.5 хувьтай байсан.	Ажлын цаг ашиглалтыг албан хаагчдын цагийн бүртгэлийн программд тухай бүр бүртгүүлж, бүртгүүлээгүй тохиолдолд хүсэлтийг холбогдох нэгжид хүргүүлэн, өмнөх оноос сайжруулсан байна.	Биелэлт: Ажлын цаг ашиглалтыг албан хаагчдын цагийн бүртгэлийн программд тогтмол бүртгүүлж, гадуур сурвалжилга болон мэдээ авах үедээ тухай бүр нь сөр программаар хүсэлт илгээн баталгаажуулж, цаг ашиглалтыг чанд баримтлан ажилласан. Хүрсэн түвшин: Ажлын цаг ашиглалт бүрэн. Өвчтэй 4 сард 5 хоног, 4 сард 5 хоног, Албаны даргаас чөлөө авсан 4 удаа нийт 9 цаг, тасалсан цаг байхгүй.	2025.01.01 - 2025.06.05	90
10	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	1.Харьяа гаалийн газар хороодод 2 албан бичгээр чиглэл, зөвлөмж хүргүүлж биелэлтийг хангуулан ажилласан. 2.Тус газрын албан хаагчаас	1.ЗББНДБ болон харьяа гаалийн газар, хороодод чиг үүргийн дагуу хамтран ажилласан байна. 2.Цаг үеийн шинжтэй бусад арга хэмжээ, нэгжийн үйл ажиллагаанд ашиглагддаг	Биелэлт: 1. Гаалийн байгууллагын “Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах журам” -ын төсөл боловсруулж Мэргэжлийн зөвлөлийн хуралд оруулахаар ЗУГ-т илгээсэн. 2. ГЕГ-ын Эцэг эхийн зөвлөлийн гишүүнээр томилогдож 2025 оны ажлын төлөвлөгөөг гаргаж ажилласан. 3. Хүүхэд гэр бүлд ээлтэй байгууллагын соёлыг бий болгох зорилгоор “ГЭРЭЛТ ИРЭЭДҮЙ” өдөрлөгийг	2025.01.01 - 2025.06.05	98

			цаг үеийн шинжтэй нийт 1 ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажилласан байна	программын шинэчлэлт, хөгжүүлэлт, ажлын хэсгийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулсан болон бүрэлдэхүүнд нь ажилласан байдал, аливаа зөвлөмжийн биелэлтийг хангана.	зохион байгуулах ажлын хэсэгт орж зохион байгуулсан. 4.Гаалийн байгууллагын авлигын эсрэг хийх ажлын төлөвлөгөөний биелэлтийг хангаж ажилласан. Үүнд: - Гаалийн байгууллагын брошюрын эх бэлтгэл - Хамтран ажилладаг байгууллагуудын үйл ажиллагааг гаалийн үйл ажиллагаанаас ялгаж ойлгогдох шторкны зохиол бичих - Эмийн лицензийн программыг сурталчлах чиглэлээр Санхүүгийн мэдээллийн технологийн Төв УТҮГ-аас видео яриа авсан байна. 5. УХШИГГ, УБГГ-ын зохион байгуулсан нээлттэй хаалганы өдөрлөгт хэвлэл мэдээлэл хариуцсан албан хаагчаар ажиллаж сурталчлах ажлыг зохион байгуулсан Хүрсэн түвшин: 1. “Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах журам” -ын төсөл 90 хувь 2. ГЕГ-ын Эцэг эхийн зөвлөлийн гишүүнээр томилогдож 2025 оны ажлын төлөвлөгөөг гаргаж ГЕГ-ын даргаар батлуулсан. 3. ГЭРЭЛТ ИРЭЭДҮЙ” өдөрлөгийн зохион байгуулалт 100 хувь 4. Гаалийн байгууллагын авлигын эсрэг хийх ажлын төлөвлөгөөний биелэлт 50 хувь 5. УХШИГГ, УБГГ-ын мэдээлэл сурталчилгаа 100 хувь		
Зорилт 3. Ногоон хөгжлийг дэмжих хууль тогтоомжийг хэрэгжүүлэх							
11	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт	Олон нийтэд түгээсэн мэдээллийн төрөл, нэвтрүүлгийн тоогоор	Бидний нэг гаалийн албан хаагчийг сурталчилсан видео контент	Гаалийн байгууллагын олон нийтэд хүргэх мэдээллийн төрлийг нэмэгдүүлж, улирал бүр нэвтрүүлэг бэлтгэн гарга олон нийтэд 2	Биелэлт: 1. 2025 оноос шинээр “Асуувал хариулъя” контентыг гаргаж эхэлсэн. Найруулагчийн зохиолыг гаргаж, мэдээлэл өгөх хэрэгцээ шаардлага, сэдвийг тодорхойлох саналыг	2025.01.01 - 2025.06.05	100

			нийт 2 дугаар хийсэн	нэвтрүүлэг байна	түгээсэн	ЗББНДБ-уудаас авч, 27 санал ирснээс 11 дугаарыг бэлтгэж олон нийтэд түгээсэн 2. “Гааль” подкастын тайз, найруулагчийн болон нэвтрүүлгийн зохиолыг гаргаж УБГГ, СТ-тэй хамтран 2 дугаарыг бэлтгэн түгээсэн байна. Хүрсэн түвшин: 3. “ Асуувал хариулъя ” контентыг Монголын гааль пэйж хуудсаар сард дунджаар 8-10 мянга гаруй үзэлт хандалтыг авсан байна. 4. УБГГ, СТ-тэй хамтран бэлтгэсэн Гааль подкастын бичлэгийн хандалт 1-2 мянга, рийлсийн хандалт нь 70 мянгад хүрсэн байна		
--	--	--	----------------------	------------------	----------	--	--	--

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
1	Англи хэлний мэдлэгээ дээшлүүлэх	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Англи хэл бие даан сурч, хэлний мэдлэгээ дээшлүүлсэн.	Сургалтын төвөөс зохион байгуулах Англи хэлний сургалтад хамрагдан мэдлэгээ дээшлүүлсэн байна.	"Gereltuya Academic English Coach" сургалтын төвд сурсан	2025.01.01-2025.06.05	100
2	Сургалтад хамрагдаж мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн байх	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	МУИС-ийн Хэвлэлийн эрх чөлөөний өдөрт зориулсан “Хэвлэлийн эрх чөлөө ба олон нийт” сэдэвт сургалт уулзалтад оролцов.	Гаалийн хэргийн мэдлэг, ур чадвараа сайжруулсан байна.	- Content Con хөтөлбөрт хамрагдаж Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль, чанартай контент хийх техник ур чадвар зэрэг сэдвийн хүрээнд мэдлэгээ дээшлүүлсэн байна.	2025.01.01-2025.06.05	100

					- МУИС-ийн Хэвлэлийн эрх чөлөөний өдөрт зориулсан “Хэвлэлийн эрх чөлөө ба олон нийт” сэдэвт сургалт уулзалтад оролцов.		
--	--	--	--	--	--	--	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ АЛБАНЫ
ГААЛИЙН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ
(Албан тушаал)

Б.САЙХАНЗАЯА /..... /
(Нэр, гарын үсэг)

2025.06.10
(Огноо)

ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:

ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ
АЛБАНЫ ДАРГА

Б.МӨНХ-АМАР /..... /
(Нэр, гарын үсэг)

2025.06.10
(Огноо)

**ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ БАТСҮХИЙН САЙХАНЗАЯАГИЙН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Олон нийттэй харилцах алба

1. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 2. Хууль сахиулах, аюулгүй байдлыг хангах					
1.	Байгууллагын үйл ажиллагаа болон холбогдох хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарч буй мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, удирдлагыг мэдээллээр хангаж ажилласан байдал	59	9	68	
Зорилт 1. Хууль ёсны худалдааг хөнгөвчлөх					
2.	Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран мэдээлэл солилцох, байгууллагыг төлөөлөн хамтран ажиллах, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ярилцлага, мэдээлэл өгөх албан хаагчид мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгсөн байдал	59	9	68	
Зорилт 3. Ногоон хөгжлийг дэмжиж, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх					
3.	Байгууллагын цахим хуудсыг хөгжүүлэх	59	9	68	

4.	Гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой видео танилцуулга, хэвлэлийн эх бэлтгэсэн байдал	59	9	68	
5.	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	59	9	68	
Зорилт 1. Хууль ёсны худалдааг хөнгөвчлөх					
6.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт	59	9	68	
7.	Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал	59	9	68	
8.	Үүрэг даалгаврын биелэлт	59	9	68	
9.	Ажлын цаг ашиглалт	59	9	68	
10.	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт	59	9	68	
Зорилт 3. Ногоон хөгжлийг дэмжиж, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх					
11.	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт	59	9	69	
Дундаж оноо:				68.1	

2. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийг хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4
1.	Англи хэл бие даан сурч, хэлний мэдлэгээ дээшлүүлсэн.	100	15	

2.	Content Con хөтөлбөрт хамрагдаж Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль, чанартай контент хийх техник ур чадвар зэрэг сэдвийн хүрээнд мэдлэгээ дээшлүүлсэн байна.	100	15	
Дундаж оноо:			15	

3. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (НЭГЖИЙН ДАРГЫН ҮНЭЛГЭЭ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1.	Хандлага, ёс зүй	6.7	
2.	Асуудал шийдвэрлэх	6.7	
3.	Хариуцлагатай байдал	6.7	
4.	Дүн шинжилгээ хийх	6.7	
5.	Ажлын цаг ашиглалт	6.7	
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)			
6	Мэргэжлийн ур чадвар 1. Асуудал шийдвэрлэх, шийдвэр гаргах ур чадвар	6.7	
7	Мэргэжлийн ур чадвар 2. Бүтээлч байдал	6.7	
8	Мэргэжлийн ур чадвар 3. Судалгаа, дүн шинжилгээ, дүгнэлт хийх ур чадвар	6.7	
Дундаж оноо:		6.7	

4. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (ХАМТ ОЛНЫ ҮНЭЛГЭЭ)

Д/д	Хандлага, ёс зүй, ур чадвар	Хамт олны үнэлгээ (0-8)
	1	2
1.	Хандлага, ёс зүй	7.7
2.	Багаар ажиллах	7.7
3.	Харилцаа	7.7

Дундаж оноо: 7.7

5. ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (<i>Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно</i>)	68.1
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	15
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (<i>Нэгжийн даргын үнэлгээ</i>)	6.7
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (<i>Хамт олны үнэлгээ</i>)	7.7
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (<i>Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих</i>)	<i>Байхгүй</i>
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (<i>Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ</i>))- Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		97.5

Үнэлгээ өгсөн:

Олон нийттэй харилцах алба
даргын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч
(албан тушаал)

Нэгжийн дарга


.....
(гарын үсэг)


/ Б.Мөнх-Амар /
(албан хаагчийн нэр)

2025.06.10 (огноо)

**Үнэлгээтэй танилцаж,
зөвшөөрсөн:**

Гаалийн улсын ахлах байцаагч
(албан тушаал)

Төрийн хинхэнэ албан хаагч:


.....
(гарын үсэг)

/ Б.Сайханзаяа /
(албан хаагчийн нэр)
2025.06.10 (огноо)

Үнэлгээг хянасан :

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:
Дэд даргын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч
(албан тушаал)


.....
(гарын үсэг)

/ Г.Энхтайван /
2025.06.10 (огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:
Хүний нөөцийн хэлтсийн гаалийн улсын
ахлах байцаагч
(албан тушаал)



.....
(гарын үсэг)

/ Ө.Тэгшээ /
2025.06.25 (огноо)

Үнэлгээг баталгаажуулсан:

Гаалийн ерөнхий газрын дарга
(албан тушаал)

Төсвийн шууд захирагч


.....
(гарын үсэг)

/ Р.Отгонжаргал /
2025.06.25
(огноо)